



СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 1/ЧЗ

Цагаантолгой

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, сумын Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.3.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын ивээл дор зохион байгуулагдах "Авьяаслаг Сантчууд" урлаг-спортын наадмыг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: А.Одхүү- (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: С.Сайнхишиг-(Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн)

Д.Өлзийбадрах-(Ерөнхий боловсролын сургуулийн захирал)

Л.Хүрэлмаа-(1-р цэцэрлэгийн эрхлэгч)

Э.Очгэрэл-(Эрүүл мэндийн төвийн дарга)

Д.Баярсүрэн-(Соёлын төвийн эрхлэгч)

Г.Ууганцэцэг-(Санхүү албаны дарга)

2. "Авьяаслаг Сантчууд" арга хэмжээг 2022 оны 10 сарын 31-ний өдрөөс 2023 оны 03 сарын 17-ны өдөр хүртэл удирдамжийн дагуу үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсэгт даалгасугай.

3. Энэхүү арга хэмжээг иргэд олон нийтэд мэдээллэн сурталчилан багийн иргэдийг бүрэн хамруулж ажиллахыг Ивэн багийн Засаг дарга (Л.Сэлэнгэсайхан), Хушаат багийн Засаг дарга (Б.Золбаяр) нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Мөнх-Эрдэнэ) -д даалгасугай.



С.ШИЖИРБААТАР



Боловсруулсан: С. Саломонзон
Хянасан: Ч. Аюулзан
Хувь: 2